



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 1132

Баян-Овоо

**Эрсдэлийн сангаас зардал гаргах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон хоногийн үргэлжилсэн борооны улмаас Онон, Балж гол нь аюултай түвшнээс 1 метр давж үерлэн Онон голын гүүрний 2 талын далан сэтэрч, Балж голын бирваз хаагдаж аюултай байдалд шилжсэний улмаас постонд гарч ажилласан албан хаагчдын хоол хүнсэнд 603000 (Зургаан зуун гурван мянга) төгрөг, аймгийн Онцгой байдлын албан хаагчдын хоол хүнсэнд 1.286.000 (Нэг сая хоёр зуун наян зургаан мянга) төгрөг, Онон голын далан засварлах, Балж голын усанд идэгдсэн гуу жалга засварлах тээвэр шатахууны зардал 5.516.900 (Таван сая таван зуун арван зургаан мянга есөн зуун) төгрөг, иргэдийн аюулгүй байдал хангах зорилгоор ашигласан 82 метр олсны үнэ 205000 (Хоёр зуун таван мянга) төгрөгийн зардлыг тус тус гаргасугай.

2.Нийт 7.610.900 (Долоон сая зургаан зуун арван мянган есөн зуун) төгрөгийн зардлыг эрсдлийн сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД

010000348